



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/227

Мандлговь

Малд үзлэг ангилалт, хянан
баталгаажуулалт хийх тухай

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8, Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн 3.2.1.1, 3.2.4.2 дахь заалт, Аймгийн Засаг дарга, ХХААХҮЯ сайдтай 2018 онд хамтран ажиллах гэрээний 9-р заалт, Мал эмнэлэг үржлийн газрын даргын А/18 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Өндөршил сумын адуу, Сайнцагаан сумын хонь, Хулд сумын тэмээн сүрэгт хавсралтад заасны дагуу үзлэг ангилалт хийж, хээлтүүлэгч шинээр нөхөн тавих, баталгаажуулах, бүртгэлжүүлэх ажлыг 2018 оны 5 сарын 25 -наас 2018 оны 10 сарын 15-ны дотор зохион байгуулж тайланг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэхийг холбогдох сумдын Засаг дарга нарт даалгасугай.

Хоёр. Үзлэг ангилалт, хянан баталгаажуулалтын ажлыг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал), биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТЭРДЭНЭ

0200665

Аймгийн Засаг даргын 2018 оны 5 дугаар сарын 25-ны
өдрийн /16/ зоот захирамжийн хавсралт



Нутгийн мал сүрэгт үзлэг, ангилалт хийх хуваарь

2018.05.18

№	Аймаг	Сум	Малын төрөл	Ангилалтанд хамрагдах мал		
				Нийт	Хээлтүүлэгч	Хээлтэгч
1	Дундговь	Сайнцагаан	Хонь	8000	200	7800
2		Өндөршил	Адуу	2500	50	2450
3		Хулд	Тэмээ	2000	30	1970
4	Нийт		Бог	8000	200	7800
5			Бод	4500	80	4420